



Институтийн суралцахуйг
өндөрт гаргах туршлага

Институтийн суралцахуйг өндөрт гаргах туршлага

Санал хүсэлт ба залруулгыг талархан хүлээн авна. Та санал хүсэлтээ дараах хаягаар илгээнэ үү.

Seminaries and Institutes of Religion Curriculum Services
50 East North Temple Street
Salt Lake City, Utah 84150-0008
USA

Э-мэйл хаяг: ces-manuals@ldschurch.org
Нэр, хаяг, тойрог, гадсаа бүрэн гүйцэд бичнэ үү.

Мөн гарын авлагынхаа нэрийг бичээрэй. Дараа нь санал хүсэлтээ бичнэ үү.

© 2016 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв
1-р хувилбар, 11/16

Англи эхийн зөвшөөрөл: 8/16
Орчуулгын зөвшөөрөл: 8/16
Institute Elevate Learning Experience-ийн орчуулга
Mongolian
PD60002572 363

Гарчиг

Институтийн суралцахуйг өндөрт гаргах туршлагын оршил	v
Суурийн чулуу ангийн асуултууд	1
Мөнхийн гэр бүл (Шашин судлал 200)	3
Сэргээлтийн үндэс (Шашин судлал 225)	6
Есүс Христ ба үүрдийн сайн мэдээний багшийн гарын авлага (Шашин судлал 250)	10
Мормоны Номын сургаал ба номлол (Шашин судлал 275)	14
Сонгон суралцах ерөнхий ангийн асуултууд	17
Тэмдэглэлийн дэвтэр	20
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан зохицуулалт хийх нь	22

Институтийн суралцахуйг өндөрт гаргах туршлагын оршил

Суралцахуйг өндөрт гаргах туршлага нь суралцагчдад Бурханы үгээр маш чухал туршлага олж авах боломжийг олгох зорилготой. Суралцагчид Есүс Христийн сургаалыг илүү бүрэн дүүрэн ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэн, бусадтай хуваалцсанаар энэхүү зорилгод хүрэх магадлал нь өсөн нэмэгддэг. Курс бүрээс кредит оноо цуглуулахын тулд Суралцахуйг өндөрт гаргах туршлагын дараах гурван сонголтоос аль нэгийг хийж дуусгах шаардлагатай. Үүнд:

1. Суралцахуйг өндөрт гаргах асуултууд: Суралцагчид хичээлийн турш судлах асуултуудыг тунгаан бодож, хариулна. Энд Суурийн чулуу болох дөрвөн анги тус бүрийн онцлогт тохирсон асуултууд байхаас гадна бусад бүх ангид зориулан сонгосон ерөнхий асуултын хувилбар ч бас байна. Судлах асуултуудын холбоосыг доор оруулав.



Мөнхийн гэр бүл (Шашин судлал 200)



Сэргээлтийн үндэс (Шашин судлал 225)



Есүс Христ ба үүрдийн сайн мэдээний багшийн гарын авлага (Шашин судлал 250)



Мормоны Номын сургаал ба номлол (Шашин судлал 275)



Сонгон суралцах ерөнхий ангиуд

2. Тэмдэглэл: Суралцагчид сурч мэдсэн зүйлсээ болон эдгээрийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж байгаагаа мөн тэдний туршлага Есүс Христэд итгэх итгэлийг нь хэрхэн хүчирхэгжүүлж байгааг бичиж тэмдэглэнэ.



3. Суралцах хувийн төсөл: Суралцагчид багшийн зөвшөөрсөн суралцах хувийн төслийг хийх төлөвлөгөө гарган, хийж гүйцэтгэнэ. Энэ төсөл нь ангид ярьсан сургаал, зарчмуудыг хэрхэн судлах мөн хэрэгжүүлэхийг тайлбарладаг бөгөөд суралцагчдын Есүс Христэд итгэх итгэл хэрхэн хүчирхэгжсэнийг дүгнэнэ.



Суралцахуйг өндөрт гаргах туршлагыг хэрхэн ашиглах талаарх сургалтыг “How to Use the Elevate Learning Experience” (LDS.org) видео бичлэгээс үзнэ үү.

Суралцагчид эрт эхэлж, үүн дээрээ тогтмол ажиллан, бусдын санал зөвлөгөөг эрэлхийлж мөн олж авсан туршлагаа гэр бүлийнхэн, найз нөхөд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хуваалцсанаар энэ туршлагаа илүү сайн үр

дүнд хүргэнэ. Суралцагчдад Есүс Христийн болон Түүний сайн мэдээний талаар мэдэж авсан зүйлсээ тайлбарлах, хуваалцах, гэрчлэх боломжуудыг олгохоор тооцож, хичээлийн цагийг төлөвлөж болно. Хичээл бүрийн дараа суралцагчид сайн мэдээний үзсэн зарчмынхаа талаар ойлгож авсан зүйл, түүнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх зэргийг тусган, суралцах хувийн төсөл дээрээ санаа оноогоо нэмэх юм уу засаж залруулах боломжтой.

Курс төгсөх дөхөхөд суралцагчдыг хийж дуусгасан төслөө хураалгах юм уу хийж дууссанаа тайлагнахад урь. Багшийн санаа оноо чухал ч гэсэн суралцагчдын Есүс Христэд итгэх итгэлийг хүчирхэгжүүлэх явдал үндсэн зорилго нь гэдгийг бүү март. Суралцагчдыг чухал сургаал, зарчмуудын талаар ойлгосон зүйлсээ үнэлж дүгнэн, амьдралдаа хэрэгжүүлэх үед итгэл нь хүчирхэгждэг. Тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн ямар нэгэн асуудалтай суралцагчдад Суралцахуйг өндөрт гаргах туршлагыг хийж гүйцээхэд тусламж шаардлагатай болж болох юм.

Санал хүсэлтээ si-research@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Суурийн чулуу ангийн асуултууд

Багшид зориулсан зааварчилгаа

Энэхүү Суралцахуйг өндөрт гаргах туршлагыг Суурийн чулуу ангид суралцаж буй институтийн суралцагчдад зориулсан болно. Уг суралцахуйн туршлага нь унших даалгавар гүйцэтгэхэд болон ангид идэвхтэй оролцоход чухал нэмэлт материал болох цогц асуултуудаас бүрддэг. Суралцагчдын хариулт урт байх шаардлагагүй ч тэдний хамгийн сайнаараа хичээж байгааг илэрхийлж байх ёстой. Суралцагчид хичээлийн туршид таны тусламжтай эдгээр асуултын хариултыг бичиж, шалгаж, засаж өөрчлөн, хураалгах боломжтой байх юм. Хэдийгээр та суралцагчдыг ангиас гадуур хариултаа бичихийг нь дэмжиж болох ч хичээлийн тодорхой цагийг үр бүтээлтэй зарцуулахаар шийдэж болно.

Түүнчлэн хичээлийг хэрхэн удирдан явуулах, шалгах зэрэг нарийн ширийн зүйлийг хөтөлбөр бүрд оруулах хэрэгтэй ч дараах алхам нь танд болон танай суралцагчдад амжилттай туршлага олж авахад тусална.

1. *Бэлтгэ.* Энэ цуврал хичээлийг эхлэхийн өмнө давтлагын өдөр болон суралцагчдад асуулт болгонд хариулсан хариултаа хураалгах эцсийн хугацааг тогтоож өг. Зарим багш улирлын эцэст бүх хариултыг нэг өдөр хураан авч шалгах хүсэлтэй байдаг байж болно. Зарим нь уг курс хичээлийн явцад тогтмол нэг удаад нэг асуултын хариултыг хураан авч, шалгаж байхаар шийдэж болно. Та суралцагчдад хичээлтэй нь холбоотой асуултуудад хариулахыг даалгавар болгож өгөхөөсөө өмнө заах ёстой хичээлийн материалыг ангид заасан байх ёстой.
2. *Тавих шаардлагуудаа тодорхой болго.* Хичээл эхлэхийн өмнө суралцагчдад Суралцахуйг өндөрт гаргах туршлагын товхимлын хувийг тарааж өг. Энэхүү хөтөлбөрийн зорилго, тавих шаардлага, үзсэн хичээлийг шалгаж, хариултыг хураан авах огноо зэргийг цөөн минутад багтаан, тодорхой тайлбарла.
3. *Бататга.* Ангид заах явцад бүх суралцагчийг Суралцахуйг өндөрт гаргах туршлагын хөтөлбөрийг тогтоосон хугацаанд хийж дуусгахад байнга урамшуулан дэмжиж, тусалж бай.
4. *Шалга.* Шалгахаар төлөвлөсөн өдрүүддээ суралцагчдыг хариултуудаа ангид авчрахад урьж мөн энэ тухай сануул. Шалгалтын зорилго нь суралцагчдыг хариултуудаа үнэлж дүгнэн, сурч мэдсэн зүйлээ хуваалцахад туслах явдал юм. Суралцагчид нэг нэгнийхээ ажлыг хос хосоороо эсвэл жижиг бүлгээрээ хуваагдан шалгавал тэдэнд ашигтай. Та суралцагчдыг сурч мэдсэн зүйлээ тайлбарлан, хуваалцаж, гэрчлэхэд урьснаар давтлагыг илүү үр дүнтэй болгох боломжтой (*Сайн мэдээг заах ба судлах нь: Шашны институт, семинарын багш, удирдагчдад зориулсан гарын авлага* [2012], 10-ыг үзнэ үү). Та шалгахдаа асуулт тус бүрд 10-аас 15 минут зарцуулах ёстой. Шаардлагатай бол эцсийн хариултаа хураалгахаас өмнө хариултуудаа хянаж үзэхэд суралцагчдыг урамшуулан дэмж.

5. *Хураалга.* Анги төгсөх үед суралцагчид хариултуудаа танд өгч хураалгана. Суралцагчид багшийн үнэлснээр уг курс хичээлтэй холбоотой бүх асуултад хариулахын тулд тодорхой хичээл зүтгэл гаргаж, бичиж мөн хянасны дараа хариултуудаа багшид хураалгасан бол Суралцахуйг өндөрт гаргах туршлагыг дүүргэсэнд тооцно. Хариултаа хураалгасан суралцагчдыг УХААЛАГ дүнгийн дэвтэрт бүртгэж ав.

Анхаарах зүйл: Онцгой хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн асуудалтай суралцагчдыг бусад суралцагчтай ижил түвшинд энэ шалгалтад оролцуулахын тулд тэдэнд зориулан шаардлагатай зохицуулалт хийсэн байхад анхаар. Хичээлийн материалыг том үсгээр хэвлэх эсвэл аудио бичлэг хэлбэрээр бэлтгэх зэргээр зохицуулж болох бөгөөд энэ нь суралцагчдад бусдын тусламжтай хариулах, хариултаа бичгээр биш амаар өгөх, бичээчээр бичүүлэх, дуу хураах төхөөрөмжөөр бичиж өгөх зэрэг боломж олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэх талаар ерөнхий мэдээлэл олж авахын тулд lds.org/topics/disability вэбсайт руу орно уу.

Суралцагчдад зориулсан зааварчилгаа

Энэхүү Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөр нь таныг хичээлдээ оролцож, уншихаар даалгавар болгосон материалыг судлахад чухал тус нэмэр болох иж бүрэн асуултуудаас бүрдэж байна. Тухайн курс хичээлийн туршид эдгээр асуултын хариулт дээр ажиллах нь сурч мэдсэн зүйлийнхээ талаар тунгаан бодож, хуваалцахдаа сайн мэдээний талаарх ойлголт, хэрэгжүүлэлтээ илүү гүнзгийрүүлэхэд тусална. Асуулт тус бүрд хариулахдаа дараах алхмыг хийж гүйцэтгэ. Үүнд:

1. Асуулт бүрд өөрийн үгээр цэгцтэй хариулж *бич*. Хариулт болгоноо судар болон бошиглогчдын үгсээр бататга. Таны хариулт бусадтай хуваалцахад тохиромжтой болсон эсэхийг магадал.
2. Хариултаа багшийнхаа тогтоосон өдөр ангид авчирч, *шалга*.
3. Шаардлагатай бол шалгасныхаа дараа хариултаа *засаж өөрчил*.
4. Бүх асуултын эцсийн хариултыг багшийнхаа өгсөн өдөрт багтаан *хураалга*.

Хэрэв өөрөөр заагаагүй бол та хариултаа ангиас гадуур хийж гүйцэтгэх ёстой. Хэрэв та онцгой хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн асуудалтай бол багштайгаа ярилцаж, энэ хөтөлбөрт хамрагдаж төгсөхөд тань тус болох зохицуулалтыг хийлгэ. Багш тань таныг энэ хөтөлбөрт амжилт гаргаасай гэж хүсэж байгаа бөгөөд амжилт гаргахад тань туслахад бэлэн байна.

Мөнхийн гэр бүл (Шашин судлал 200)

Асуултууд

1. Гэр бүл яагаад Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний төвд байдаг вэ?

Таны хариулт дараах зүйлсийг хамарсан байх ёстой. Үүнд:

- Авралын төлөвлөгөөний үндсэн зорилгуудын тодорхойлолт;
- Зөв шударга гэр бүлүүд эдгээр зорилгыг мөнхөд биелэхэд хэрхэн тусалж чадах талаарх тайлбар;
- Яагаад гэр бүлийн тухай сургаал танд болон таны мөнхийн хөгжилд чухал болох тухай тайлбар;
- Авралын төлөвлөгөөн дэх гэр бүлийн чухал үүргийг ойлгох нь энэ амьдралдаа хийдэг сонголтуудад тань хэрхэн нөлөөлж чадах талаарх тайлбар;



2. Гэрлэлтийн талаар Их Эзэний ямар ямар жишиг байдаг вэ?

Таны хариултад дараах тайлбар орсон байх ёстой. Үүнд:

- Эхнэр нөхөр, эцэг эхчүүдийн тэнгэрлэг үүрэг, хариуцлага;
- Гэрлэлт, гэр бүл дэх Аврагчийн үүрэг;
- Гэрлэлт дэх ариун, үнэнч байдлыг бий болгодог хуулиуд ба эдгээр хуулийн мөнхийн шинж чанар;
- Таны гэрлэхэд болон гэр бүлтэй болоход бэлтгэж эсвэл сайжруулахын тулд эдгээр зарчмыг хэрэгжүүлж чадах арга замууд зэрэг юм.

3. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” (*Ensign* эсвэл *Liahona*, 2010 оны 11-р сар, 129) энэ ангийн турш таны амьдралд хэрхэн эергээр нөлөөлсөн бэ?

Та өмнөх хариулт дээрх санаагаа дэлгэрүүлэн эсвэл санаануудыг хооронд нь холбож эсвэл шинэ сэдвээр бичиж болно. Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Гэр бүлийн тунхагас тодорхой нэг зарчим эсвэл сургаалыг судар юм уу хожмын үеийн бошиглогчдын үгсийг ашиглан тайлбарласан тайлбар;
- Бошиглогчдын зөвлөгөөг дагах нь таны сонгосон зарчим эсвэл сургаалыг ойлгоход танд хэрхэн тусалсан тухай жишээ;
- Та нар өөрсдөө эсвэл өөр хэн нэгэн хүн гэр бүлийн тунхаг дээрх зөвлөгөөг анхааран сонссоноор адислагдсан жишээнүүд;

- Та сонгосон зарчим эсвэл сургаалынхаа дагуу илүү бүрэн дүүрэн амьдрахын тулд юу хийж чадах тухай гэх зэрэг юм.

Сургаалын гол санаа

Энэ ангид үзэх хичээлд орсон гол санаануудыг ашиглан дараах мэдээллийг бүрдүүлсэн. Эшлэлүүдийн арын хаалтан доторх дугаарууд нь тухайн мэдэгдлийг *Мөнхийн гэр бүл багшийн гарын авлага* (2015) дээрээс олж болох хичээлийн дугаарыг харуулж байгаа болно. Хариултаа доорх мэдээлэлтэй харьцуул. Хэрэв танд энэ шалгалтаар хариултандаа оруулалгүй үлдээсэн сургаалын гол санаа байвал хариултаа хураалгахын өмнө засаж өөрчил. Та энэ мэдээллийг үгчлэн хуулах хэрэггүй бөгөөд зөвхөн эдгээр сургаалыг ойлгон, ойлгосон зүйлээ буулган бичсэн байх ёстой. 3-р асуултад илүү хувийн шинж чанартай хариулт өгөх шаардлагатай тул уг асуултад гол санаа гэж байхгүй болно.

1. Яагаад гэр бүл Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний төвд байдаг вэ?

Авралын төлөвлөгөөний үндсэн зорилгууд:

- “Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө нь бидэнд Тэнгэрлэг Эцэг эхтэйгээ илүү адилхан болох арга замыг өгдөг (3).
- “Бурханы хүүхдүүдийн үхэшгүй байдлыг хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрахад туслах зорилгоор дэлхийг бүтээсэн” (4).

Зөв шударга гэр бүлүүд эдгээр зорилгыг мөнхөд биелэхэд хэрхэн тусалж чадах вэ?

- “Гэр бүл нь Бурханы мөнх бус байдлын өмнөх амьдрал, мөнх бус байдал ба мөнх амьдралд зориулсан төлөвлөгөөний төвд байдаг” (6).
- “Адам, Ева хоёр унасан учраас хүүхэдтэй болж, тэдний үр удам мөнх амьдрал руу хөгжих боломжтой болсон” (4).
- “Бид мөнх бус бие махбодоор дамжуулан биднийг мөнх амьдралд бэлтгэж чадах мөнх бус амьдралын нөхцөл байдлуудыг үзэж туулдаг” (5).
- “Бид гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орсноор селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлүүлж чадна” (15).

2. Гэрлэлтийн талаар Их Эзэний ямар ямар жишиг байдаг вэ?

Эхнэр нөхөр, эцэг эхчүүдийн тэнгэрлэг үүрэг, хариуцлагууд:

- “Эхнэр, нөхөр хоёр бие биеэ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129).
- “Эхнэр, нөхөр хоёр дэлхийд үр хүүхдүүдийг авчрах замаар Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний нэг хэсгийг биелүүлдэг” (17).
- “Бие биенээ хайрлаж, бие биедээ үйлчлэхийг мөн Бурханы зарлигуудыг сахиж, хуулийг дээдлэн сахидаг иргэд байхыг хүүхдүүдээ заах ёстой хэмээн эцэг эхчүүдэд зарлигладаг” (22).

Гэрлэлт ба гэр бүл дэх Аврагчийн үүрэг:

- “Есүс Христийн Цагаатгал нь эцэстээ Тэнгэр дэх Эцэгийн амласан бүх адислалыг хүлээн авах боломжийг бидний хүн нэг бүрд олгодог” (24).
- “Гэр бүлүүд Есүс Христ дээр сууриа тавивал Сатанд тэднийг устгах хүч байхгүй байх болно” (19).

Гэрлэлт дэх ариун, үнэнч байдлыг бий болгодог хуулиуд болон эдгээр хуулийн мөнхийн шинж чанар:

- “Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129).
- Түүнчлэн “үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр, нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээн Бурхан зарлигласан (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” 129) (16).
- “Иргэний хуулинд орсон өөрчлөлт Бурханы тогтоосон ёс суртахууны хуулийг өөрчлөхгүй. Бурхан нийгмийн өөр өөр үзэл санаа, чиг хандлагаас үл хамааран биднийг Өөрийнхөө зарлигуудыг дагаасай хэмээн хүсдэг” (Gospel Topics, “Same-Sex Marriage,” lds.org/topics) (7).

Сэргээлтийн үндэс (Шашин судлал 225)

Асуултууд

1. Бид үнэн, худал хоёрыг хэрхэн ялган таних вэ?

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Судрууд, өнөө үеийн бошиглогчдын үгс, Ариун Сүнс зэргийн үнэнийг тогтооход гүйцэтгэх үүрэг
- Судлах, итгэлтэй байх, залбирах зэрэг нь үнэний тухай мэдэж авахад танд хэрхэн тусалж чадах тухай
- Сүмийн түүх болон Сүмийн илчлэгдсэн сургаалын тухай найдвартай эх сурвалжуудыг хэрхэн олж, үнэлж дүгнэн, ашиглах тухай
- Та эсвэл таны мэддэг хэн нэгэн шийдвэрлэх асуудал, сорилт бэрхшээл, асуудалтай тулгарсан үед үнэн, худлыг ялган таних талаар олж мэдсэн зарчмуудаа амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох тухай



2. “Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн” гэдгийг ойлгох нь миний хувьд яагаад чухал байдаг вэ? (С ба Г 135:3).

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Анхны үзэгдлийн Сайн мэдээний сэргээлтэд болон цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн эхлэлд гүйцэтгэсэн үүрэг
- Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн үнэн таны амьдралыг хэрхэн адисалсан тухай
- Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн санваарын түлхүүрүүд эсвэл авралын ёслолууд таны амьдралыг хэрхэн адисалсан тухай
- Иосеф Смитийн Сэргээлтэд гүйцэтгэсэн үүрэг нь таныг хэрхэн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт илүү ойр авчирсан тухай

3. Сэргээлтийн тухай доорх чухал үйл явдлууд эсвэл сургаалуудын аль нэг нь таны амьдралыг хэрхэн адисалсан бэ?

а) Мормоны Ном ирсэн нь, б) Сургаал ба Гэрээн дэх чухал хэсгүүд ба сургаалууд, в) Сүмийн илчлэгдсэн зохион байгуулалт, г) санваарын сэргээлт, д) ариун сүмүүд ба ариун сүмийн ажил. Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Та энэ ангид суралцсанаар энэ үйл явдал эсвэл сургаалын тухай юу мэдэж авсан тухай

- Энэ үйл явдал эсвэл сургаал нь тэнгэр нээлттэй байгааг хэрхэн батлан харуулдаг тухай
- Энэ үйл явдал эсвэл сургаал таны амьдралыг хэрхэн адисалсан эсвэл таны хувьд хэр чухал болох тухай
- Сэргээгдсэн сайн мэдээний тухай мэдэж авсан зүйлсийн тань талаарх таны гэрчлэл

Сургаалын гол санаа

Энэ ангид үзэх хичээлд орсон гол санаануудыг ашиглан дараах мэдээллийг бүрдүүлсэн. Эшлэлүүдийн ард байрлах хаалтан доторх дугаарууд нь тухайн мэдэгдлийг *Сэргээлтийн үндэс багшийн гарын авлага* (2015) дээрээс олж болох хичээлийн дугаарыг харуулж байгаа болно. Хариултаа доорх мэдээлэлтэй харьцуул. Хэрэв танд энэ шалгалтаар хариултандаа оруулалгүй үлдээсэн сургаалын гол санаа байвал хариултаа хураалгахын өмнө засаж өөрчил. Та энэ мэдээллийг үгчлэн хуулах хэрэггүй бөгөөд зөвхөн эдгээр сургаалыг ойлгон, ойлгосон зүйлээ буулган бичсэн байх ёстой. 3-р асуултад илүү хувийн шинж чанартай хариулт өгөх шаардлагатай тул уг асуултад гол санаа гэж байхгүй болно.

1. Бид үнэн, худал хоёрыг хэрхэн ялган таних вэ?

Үнэнийг тогтооход судрууд, өнөө үеийн бошиглогчдын үгс, үнэнийг тогтоох Ариун Сүнс гэх мэтийн гүйцэтгэх үүрэг:

- “Мормоны Ном болон Сургаал ба Гэрээ нь хүмүүний авралын төлөө Библийн хамтаар урагш авчрагдсан болно” (22).
- “Бидний уншсан зүйл үнэн эсэхийг мэдэхэд Ариун Сүнс бидэнд тусалж чадна” (10).
- “Хэрэв бид бошиглогчдын үгсэд анхаарал хандуулбал дайсны эсрэг хамгаалагдах болно” (9).
- “Их Эзэний үйлчлэгчид Ариун Сүнсний хүчээр ярих үед тэдний үг Их Эзэний хүслийг илчилдэг” (12).

Судлах, итгэлтэй байх, залбирах зэрэг нь үнэний тухай мэдэж авахад танд хэрхэн тусалж чадах тухай:

- “Бид суралцах үйл явцдаа итгэлтэй байвал Их Эзэний тусламжийг авах эрхтэй болдог” (10).
- “Бид зарлигуудыг дуулгавартай дагаж, ялангуяа амьд бошиглогчдын үгс гэх мэт зохих мэдээллийн эх сурвалжуудыг судлан, залбирлаар дамжуулан удирдамж эрэлхийлж, итгэл мөн тэвчээрийг хөгжүүлснээр хамгийн агуу асуултууддаа хариулт авч чадна” (10).
- “Бид асуулт эсвэл эргэлзээтэй тулгарах үедээ үнэн гэдгийг нь аль хэдийн мэдсэн зүйлээсээ тууштай зууран барьж, үргэлжлүүлэн судалснаар хариулт олж чадна гэдэгтээ эсвэл Бурхан нэгэн өдөр хариултыг илчлэх болно гэдэгт итгэх хэрэгтэй” (4).

Найдвартай эх сурвалжуудыг хэрхэн олж, үнэлж дүгнэн, ашиглах тухай:

- “Интернэтэд ‘үнэнийг’ шалгах шүүлтүүр байхгүй гэдгийг үнэнийг олж мэдэхийг хүсэгчдэд бид сануулж болох юм. Зарим мэдээлэл хэчнээн үнэмшилтэй ч шуудхан хэлэхэд үнэн байх нь үгүй билээ” (10; Нийл Л.Андэрсэн, “Иосеф Смит,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган,, 31).
 - “Үнэнийг эрэлхийлэгч хүмүүс буруу эсвэл хуурамч мэдээлэлд хууртахаас зайлсхийхийн тулд Сүмийн болон Сүмийн түүхийн тухай найдвартай мэдээллийн эх сурвалжуудыг эрэлхийлэх ёстой” (2).
 - “Биднийг Бурханы үг болон Түүний амьд бошиглогчдын заасан зүйлст өгөгдсөн Бурханы төлөвлөгөө, захиас хэмээн бидний мэддэг зүйлсийн эсрэг орчин үеийн үзэл санааг хэмжиж эхлэхэд ... энэ нь биднийг мөнхөд аюулгүй байх газарт аваачдаг гэдгийг бид мэддэг” (10; Даллин Х.Өүкс, “Тэрээр зүрх сэтгэлдээ тунгаахдаа” [Ахлагч Даллин Х.Өүкстэй хамт өнгөрүүлсэн нэгэн үдэш, 2013 оны 2-р сарын 8], [lds.org/broadcasts](https://www.lds.org/broadcasts)).
2. “Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн” гэдгийг ойлгох нь миний хувьд яагаад чухал байдаг вэ? (С ба Г 135:3).

Анхны үзэгдлийн Сайн мэдээний сэргээлтэд болон цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн эхлэлд гүйцэтгэсэн үүрэг:

- “Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг Иосеф Смит дээр ирэх үед мөнхийн үнэнүүд дэлхийд сэргээгдсэн юм” (2).
- “Бид Иосеф Смит Бурхан Эцэг ба Түүний Хүү Есүс Христийг харсан гэдэг гэрчлэлтэй болох юм бол Сайн мэдээний сэргээлт үнэн гэдгийг мэдэх болно” (2).
- “Иосеф Смит бидний эрин үед сайн мэдээг сэргээхийн тулд Бурханаар дуудагдсан” (1).

Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн үнэн таны амьдралыг хэрхэн адисалсан тухай:

- “Есүс Христ бол амьд, алдар суутай бие юм. Есүс Христ бол Эцэгийн Төрсөн Ганц юм. Есүс Христ бол энэ дэлхийн мөн бусад дэлхийн Бүтээгч юм” (13).
- “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь дэлхий дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм мөн” (6).
- “Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхдүүдийн хувьд бидэнд Түүнтэй адил болох чадвар байдаг” (17).
- “Их Эзэн бошиглогч Иосеф Смитээр дамжуулан үнэний тухай бидний мэдлэгийг бататгаж, тодруулж, өргөжүүлсэн нэмэлт судрыг илчилжээ” (12).

Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн санваарын түлхүүрүүд эсвэл авралын ёслолууд мөн тэдгээр нь таны амьдралыг хэрхэн адисалсан тухай:

- Иосеф Смит “номлолын ажил, мөнхийн гэр бүлүүд ба ариун сүмийн ажлын түлхүүрүүдийг” хүлээн авсан (14).

- “Хувь хүн баптисм хүртэхээсээ өмнө өөрийгөө даруусгаж, наманчилж, Есүс Христийн нэрийг өөр дээрээ авахад бэлэн байж мөн эцсээ хүртэл Түүнд үйлчлэх шийдвэр төгс байх ёстой” (6).
- “Бид селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлийг авахын тулд гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орсон байх ёстой” (19).

Есүс Христ ба үүрдийн сайн мэдээний багшийн гарын авлага (Шашин судлал 250)

Асуултууд

1. Би Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байх талаар Аврагчаас юу мэдэж сурч болох вэ?

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Аврагчийн мөнхийн тохинууллаас Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байсныг нь харуулах сургаал эсвэл жишээнүүд
- Тэнгэрлэг Эцэгтээ үзүүлсэн Есүсийн дуулгавартай байдал хэрхэн таны шавь байхтай холбоотой тухай
- Аврагчийн дуулгавартай байдлын жишээ яагаад танд чухал болох мөн хэрхэн Тэрээр танд илүү хүчирхэг шавь байхын тулд хийх хэрэгтэй алхмыг хийхэд тань туслах тухай
- Аврагчийн дуулгавартай байдлын жишээ Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байхад танд хэрхэн тусалдаг тухай

2. Яагаад Аврагч надад хэрэгтэй вэ?

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Унасан байдлаасаа болж бидний даван гарах ёстой гол шалгуурууд
- Мөнхийн тохинууллынхаа турш гүйцэтгэж байсан Аврагчийн олон үүрэг Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд эдгээр шалгуурыг давж гарахад хэрхэн тусалдаг тухай
- Бид Аврагчийн тусламжийг хүлээн авч, урьж авчрахын тулд ямар зүйл хийх хэрэгтэй тухай
- Сорилт бэрхшээл, шалгууртай тулгарахдаа Аврагчийн тэнгэрлэг тусламжийг мэдэрч байсан доод тал нь нэг арга замын тухай

3. Би энэ ангид сууснаараа Есүс Христ ба үүрдийн сайн мэдээ миний амьдралыг адисалсан ямар зүйлийг сурч мэдсэн бэ?

Та өмнөх хариулт дээрх санаагаа хөгжүүлэн эсвэл санаануудыг хооронд нь холбож эсвэл шинэ сэдвээр бичиж болно.



- Нэг эсвэл хоёр өгүүлбэрт багтаан, сурч мэдсэн сургаалаа найруулан бич.
- Энэхүү сургаалаа судруудаас авсан жишээ эсвэл бошиглогчдын үгсийг ашиглан тайлбарла.
- Аврагчийн сургаал, жишээ мөн Цагаатгал хэрхэн таны амьдралыг адисалсан тухай хуваалц.
- Есүс Христ ба үүрдийн сайн мэдээний тухай сурч мэдсэн зүйлээ гэрчилж бич.

Сургаалын гол санаа

Энэ ангид үзэх хичээлд орсон гол санаануудыг ашиглан дараах мэдээллийг бүрдүүлсэн. Эшлэлүүдийн ард байх хаалтан доторх дугаарууд нь *Есүс Христ ба үүрдийн сайн мэдээ ангийн багшийн гарын авлага (2015)* дээрээс олж болох хичээлийн дугаарыг харуулж байгаа болно. Хариултаа доорх мэдээлэлтэй харьцуул. Хэрэв танд энэ шалгалтаар хариултандаа оруулалгүй үлдээсэн сургаалын гол санаа байвал хариултаа хураалгахын өмнө засаж өөрчил. Та энэ мэдээллийг үгчлэн хуулах хэрэггүй бөгөөд зөвхөн эдгээр сургаалыг ойлгон, ойлгосон зүйлээ буулган бичсэн байх ёстой. 3-р асуултад илүү хувийн шинж чанартай хариулт өгөх шаардлагатай тул уг асуултад гол санаа гэж байхгүй болно.

1. Би Эцэгийн хүсэлд дуулгавартай байх талаар Аврагчаас юу мэдэж сурч болох вэ?

Аврагчийн тохинуулал дахь Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байсныг нь харуулах сургаал эсвэл жишээнүүд

- “Иехова бүр эхлэлээс сонгогдсон байсан. Иехова сонгогдох болсон нэг шалтгаан нь Тэрээр Эцэгийн хүслийг биелүүлж, Эцэгт бүх алдар сууг өгөхийг эрэлхийлсэн явдал юм” (2).
- “[Есүс Христ] нүгэлгүй байсан ч бүх зөв шударга ёсыг гүйцэлдүүлэхийн тулд баптисм хүртсэн юм” (8; “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм,” *Ensign* эсвэл *Liahona*, 2000 оны 4-р сар, 2).
- “Авралын төлөвлөгөө нь Цагаатгалыг гүйцэлдүүлэхийн тулд төгс дуулгавартай байхыг Есүсээс шаардаж байв” (9).
- “Би Өөрийн санаагаар юуг ч хийдэггүй, харин Эцэгийн надад зааснаар ... ; Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг” (Иохан 8:28–29).

Есүс Эцэгт дуулгавартай байсан нь таны шавь байхтай хэрхэн холбоотой болох тухай:

- “Аврагчийн адил бид үүрдийн сайн мэдээний ёслол, гэрээнүүдэд захирагдах үед зөвт байдлыг гүйцэлдүүлдэг” (8).
- “Есүс Христийн шавь байх нь дуулгавартай байдал, золиослолыг шаарддаг... Шавь байх нь бүгдийг орхиод, Есүс Христийг дагах хүслийг шаарддаг” (10).

- “Бид өөрсдийнхөө тааллын оронд Эцэгийн тааллыг эрэлхийлсэн Есүс Христийн жишээг дагаснаар уруу таталтыг ялж гаран, дуулгавартай байх хүч чадлыг олж авч чадна” (9).

2. Яагаад Аврагч надад хэрэгтэй вэ?

Унасан байдлаасаа болж бидний даван гарах ёстой гол шалгуурууд

- “Бид бүгдээрээ Бурханы оршихуйгаас салан тусгаарлагдаж, сүнсний үхлийг туулдаг бөгөөд бид бүгдээрээ бие махбодын үхэл болох зуурдын үхэлд хамааралтай юм (Алма 42:6–9; С ба Г 29:41–42)” (*Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 15).
- “Бидний уналтын байдалд бид эсрэг тэсрэг байдал болоод уруу таталтад ордог. Бид уруу татагдахдаа Бурханаас өөрсдийгөө холдуулдаг (Ром 3:23)” (*Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт*, 15).

Мөнхийн тохинууллынхаа турш гүйцэтгэж байсан Аврагчийн олон үүрэг Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдэд эдгээр шалгуурыг давж гарахад хэрхэн тусалдаг тухай:

- “Иехова Бурханы хүүхдүүдэд амьдарч, мөнх амьдралд хүрэхээр өсөж хөгжих газар өгөхийн тулд дэлхийг бүтээсэн” (4).
- “Есүс Христ маханбодод орших Бурханы Төрсөн Ганц Хүүгийн хувьд Түүнээс өөр ямар ч мөнх бус хүмүүний давж гарч чадахаас хавьгүй их зүйлийг шаардаж байсан цагаатгагч золиослолыг хийх боломжтой байсан ба ингэснээрээ Эцэгийн төлөвлөгөөн дэх Өөрийн үүргийг гүйцэтгэсэн юм” (7).
- “Бид Есүс Христийн Цагаатгалын ачаар ‘бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг’ (Алма 7:11) тэвчих тайтгарал, хүч чадлыг Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авч чадна” (16).
- “Мөнх бус байдалд төрсөн хүн бүр Есүс Христийн Цагаатгал болон Амилалтын ачаар амилуулагдаж” мөн шүүгдэхээр Бурханы оршихуйд буцаан авчрагдах болно (19).
- “Есүс сүнсний дэлхийд байхдаа нас барагсдын төлөөх авралын ажлыг зохион байгуулсан” (18).
- “Есүс Христ Эцэгийн өмнө бидний Өмгөөлөгч болой” (24).
- “Аврагч биднийг үг, бодол, үйлс болон зүрх сэтгэлийн хүслүүдийн дагуу шүүх болно” (26).

Бид Аврагчийн тусламжийг хүлээн авч, урьж авчрахын тулд ямар зүйл хийх хэрэгтэй тухай:

- “Бид Цагаатгалыг хийсэн Есүс Христэд түшиглэн мөн гэрчлэлээ хуваалцаж, үнэнч байснаар Сатаныг ялж чадна” (3).
- “Бид энэ дэлхийд байхдаа Аврагчийг амьдралынхаа төвд байлгах сонголтыг хийснээр мөнх амьдралд илүү агуу адислалуудыг хүлээн авах болно” (2).

- “Хэрэв бид ариун ёслолоос залбиралтай мөн наманчлалын сүнстэй хүртвэл баптисм хүртэх үедээ хүлээн авсантай адил нүглийнхээ ангижралыг хүлээн авч чадна” (15).
- “Бид Есүс Христийг хүлээн зөвшөөрч, Бурханы зарлигуудыг дагах гэрээ хийж, сахиснаар Христийн төрсөн охид, хөвгүүд болдог” (24).

Мормоны Номын сургаал ба номлол (Шашин судлал 275)

Асуултууд

1. Мормоны Ном таны амьдралд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Мормоны Номын гол зорилго ба үнэнийг тогтооход гүйцэтгэх үүрэг
- Мормоны Номыг судалдаг хүмүүст амлагдсан адислал
- Мормоны Номын бурханлаг гарал үүслийг ойлгох нь яагаад чухал болох
- Энэ цуврал хичээлийн турш та Мормоны Номыг судлах үедээ үзэж, мэдэрч, хүлээн авсан адислал
- Энэ цуврал хичээлээр олж авсан таны туршлагад үндэслэн Мормоны Номыг судалж, хэрэгжүүлэх байдал тань хэрхэн сайжирсан тухай



2. Мормоны Номонд өгүүлснээр Христ танд өргөмжлөлийг хэрхэн боломжтой болгосон бэ?

Таны хариултад дараах зүйлс орсон байх ёстой. Үүнд:

- Христийн сургаалын болон сургаалын дагуу амьдардаг хүмүүст амлагдсан адислалын тайлбар
- Христ бидний төлөө сүнслэг болон бие махбодын саадыг хэрхэн даван туулсан тухай
- Энэ цуврал хичээлийн турш Есүс Христэд өгсөн амлалт, талархах сэтгэл тань хэрхэн нэмэгдсэн тухай
- Та Есүс Христийг өөрийн Их Эзэн, Аврагч хэмээн хүлээн зөвшөөрдөг гэдгээ хэрхэн үзүүлдэг тухай

3. Мормоны Номын ямар ямар үнэн танд нөлөөлсөн бэ?

Та өмнөх хариулт дээрх санаагаа хөгжүүлэн эсвэл санаануудыг хооронд нь холбож эсвэл шинэ сэдвээр бичиж болно.

- Энэ цуврал хичээлд оролцсоноор танд илүү утга учиртай болсон эсвэл сурч мэдэж авсан Мормоны Номын сургаал, зарчмаас гурваас тавыг жагсааж бич.
- Жагсаалтаасаа аль нэг сургаал, зарчмыг сонгож мөн судрын жишээ, бошиглогчдын үгсийг ашиглан түүнийг гүнзгийрүүлэн тайлбарла.

- Энэ сургаал, зарчим нь танд яагаад чухал санагдсан болон үүний дагуу хэрхэн үйлдэх тухай хуваалц.
- Энэ цуврал хичээлийн турш Мормоны Номыг судалснаар мэдэж авсан зүйлийнхээ талаар гэрчлэлээ бич.

Сургаалын гол санаа

Энэ ангид үзэх хичээлд орсон гол санаануудыг ашиглан дараах мэдээллийг бүрдүүлсэн. Эшлэлүүдийн ард байрлах хаалтан доторх дугаарууд нь тухайн мэдэгдлийг *Мормоны Номын сургаал ба номлол багшийн гарын авлага* (2015) дээрээс олж болох хичээлийн дугаарыг харуулж байгаа болно. Хариултаа доорх мэдээлэлтэй харьцуул. Хэрэв танд энэ шалгалтаар хариултандаа оруулалгүй үлдээсэн сургаалын гол санаа байвал хариултаа хураалгахын өмнө засаж өөрчил. Та энэ мэдээллийг үгчлэн хуулах хэрэггүй бөгөөд зөвхөн эдгээр сургаалыг ойлгон, ойлгосон зүйлээ буулган бичсэн байх ёстой. 3-р асуултад илүү хувийн шинж чанартай хариулт өгөх шаардлагатай тул уг асуултад гол санаа гэж байхгүй болно.

1. Мормоны Ном таны амьдралд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Мормоны Номын гол зорилго ба үнэнийг тогтооход гүйцэтгэх үүрэг:

- “Бурхан бүх хүнийг Есүс бол Христ гэдэгт итгүүлэхийн тулд хожмын өдрүүдэд Мормоны Номыг авчирсан” (1).
- “Мормоны Ном нь Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг” (6).
- “Ариун Библи, Мормоны Ном хоёр хамтдаа Есүс Христийг гэрчилдэг” (7).

Мормоны Номыг судалдаг хүмүүст амлагдсан адислал:

- “Мормоны Номын бичээчид өнөө үед бидэнд тулгарч буй асуудлуудын талаар мэдэж байсан учраас уг номд заасан зүйлс бидний хувьд агуу үнэ цэнтэй” (6).
- “Бид Мормоны Номыг судалж, сургаалуудыг нь амьдралдаа хэрэгжүүлснээр өнөө үеийн чөтгөр, хуурамч сургаал, үзэл санааны эсрэг хүчирхэгжих болно” (11).

2. Мормоны Номонд өгүүлснээр Христ танд өргөмжлөлийг хэрхэн боломжтой болгосон бэ?

Христийн сургаалын тайлбар ба сургаалын дагуу амьдардаг хүмүүст амлагдсан адислалын тайлбар:

- “Бид Христэд ирж, зарлигуудыг сахиснаар Түүнтэй болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адил болж, аврагдах болно” (3).
- “Бид Христийн сургаалын дагуу амьдарснаар Цагаатгалын адислалуудаас хүртэн, мөнх амьдралыг хүлээн авч чадна” (8).
- “Бид өршөөлийн нигүүлсэнгүй адислалыг хүлээн авахын тулд наманчлалд хүргэх Христэд итгэх итгэлийг хөгжүүлэх ёстой” (16).

Христ бидний төлөө хэрхэн сүнслэг болон бие махбодын зовлон зүдгүүрийг даван туулсан талаар:

- “Есүс Христ Цагаатгалынхаа ачаар бие махбодын болон сүнсний үхлийн үр дагавруудыг ялан дийлсэн” (5).
- “Аврагч өөр дээрээ бидний өвдөлт, өвчин, сул дорой байдлыг авсан учраас биднийг мөнх бус байдлын зовлон бэрхшээлтэй нүүр тулгарах үед бидэнд туслах боломжтой болсон” (5).
- “Есүс Христ үхлийн хүлээсийг тасчсан учраас бид бүгд амилуулагдан, үхэшгүй биеийг хүлээн авна” (18).

Сонгон суралцах ерөнхий ангийн асуултууд

Багшид зориулсан зааварчилгаа

Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөрийг Суурийн чулуу ангиас бусад бүх институтийн ангид ашиглаж болно. Энэ нь унших даалгавар гүйцэтгэх болон ангид идэвхтэй оролцоход чухал хувь нэмэр оруулах асуултуудаас бүрддэг.



Суралцагчдад зарчим, сургаалыг судалж, хэрэгжүүлэн, тэмдэглэн авч, хуваалцахад тусалж, эдгээрийг хийхэд урих нь гэрчлэлээ хүчирхэгжүүлж, хөрвөлтөө гүнзгийрүүлэхэд тэдэнд тусалж чадна.

Таны заавраар суралцагчид суралцагчийн зааварчилгааны хуудсан дээрх долоон асуултын гуравт хариулна. Суралцагчдын хариулт голчлон ангиас юу мэдэж сурсан мөн хэрхэн хэрэгжүүлснийг тусгах ёстой. Хичээлийг хэрхэн удирдан явуулахтай холбоотой нарийн ширийн асуудлыг ангиас эсвэл суралцагчдаас шалтгаалан өөрчлөх хэрэгтэй байж болно. Дараах алхмууд танд болон таны суралцагчдад амжилттай туршлага олж авахад тусална.

1. *Бэлтгэ:* Хичээл эхлэхийн өмнө асуултуудыг хянаж үзэн, Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөрийг хэрхэн удирдан явуулах төлөвлөгөө гарга. Асуултыг ангид танилцуулах мөн суралцагчийн хариултуудыг хянаж үзэх, илгээх огноо, хариултын хугацаа, хэлбэр зэрэг Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөртэй холбоотой тавьж байгаа хүлээлтүүдээ тайлбарлах арга замуудыг бэлтгэлдээ багтааж болно. Танд гурван суралцагчийн хариултыг гурван өөр өдөр сонгон хянаж үзэхийг зөвлөж байна.
2. *Тавих шаардлагуудаа тодорхой болго:* Анги хичээллэж эхлэхийн өмнө суралцагч бүрд суралцагчийн зааварчилгааны хуудсан дээрх асуултуудыг хувилан тарааж өг. Энэ нь суралцагчдыг хичээлийн хагас жилийн турш асуултуудыг судалж, хэрэгжүүлэн, тэмдэглэж авах хангалттай хугацаагаар хангах болно. Тэдэнд Суралцахуйг өндөрт гаргах туршлагын зорилгыг ойлгоход тусал. Асуултуудыг хянах, илгээх огноо зэрэг тэдний өгөх хариулттай холбоотой юуг хүсэн хүлээж байгаагаа тодорхой ойлгуул.
3. *Бататга:* Ангид заах явцдаа Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөрийн асуултуудад хариулан, бөглөхөд нь бүх суралцагчид тусалж, дэмжин, урамшуул. Асуултуудыг хөтөлбөртэй уялдуулах эсвэл ангийн үйл ажиллагаанд тохируулах арга замуудыг ол. Та суралцагчдыг хариултууд дээр нь ажиллуулахдаа ангид болон хичээлээс гадуур эсвэл аль алианаар нь ажиллуулж болно.
4. *Шалгаж, зас:* Хянахаар товлосон өдрүүдийг суралцагчдад сануулж, хариултаа ангид авчрахад урь. Тэднийг хариултууддаа ангиас юу сурч,

хэрэгжүүлснээ тайлбарлан, хуваалцаж, гэрчлэхэд урь. Суралцагчид нэг нэгнийхээ ажлыг хос хосоороо эсвэл жижиг бүлгээрээ хуваагдан шалгавал тэдэнд ашигтай. Хэрэв шаардлагатай бол хариултаа илгээхээс өмнө шаардлагатай засварыг хийхэд суралцагчдыг урьж болно.

5. *Хураалга*: Суралцагчид таны заавраар гурван асуултад хариулснаа хураалгаснаар Суралцахуйг өндөрт гаргах туршлага хөтөлбөрийг хийж дуусгана. *Суралцагчийн хариултад санал бодлоо заавал хэлэх шаардлагагүй ч хэлж болно*. Хариултаа хураалгасан суралцагчдын мэдээллийг УХААЛАГ дүнгийн дэвтэрт оруул.

Анхаарах зүйл: Онцгой хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн асуудалтай суралцагчдыг бусад суралцагчтай ижил түвшинд энэ шалгалтад оролцуулахын тулд тэдэнд зориулан шаардлагатай зохицуулалтыг хийсэн байхад анхаар. Хичээлийн материалыг том үсгээр хэвлэх эсвэл аудио бичлэг хэлбэрээр бэлтгэх зэргээр зохицуулж болох бөгөөд энэ нь суралцагчдад бусдын тусламжтай хариулах, хариултаа бичгээр биш амаар өгөх, бичээчээр бичүүлэх, дуу хураах төхөөрөмжөөр бичиж өгөх зэрэг боломж олгоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэх талаар ерөнхий мэдээлэл олж авахын тулд [lds.org/topics/disability](https://www.lds.org/topics/disability) вэбсайт руу орно уу.

Суралцагчдад зориулсан зааварчилгаа

Энэхүү Суралцахуйг өндөрт гаргах туршлага таныг хичээлдээ оролцож, уншихаар даалгасан материалыг судлахад чухал хувь нэмэр оруулах асуултуудаас бүрдэнэ. Суралцагчдад зарчим, сургаалыг судалж, хэрэгжүүлэн, тэмдэглэж авч, хуваалцахад тусалж, тэдгээрийг хийхэд урих нь гэрчлэлээ хүчирхэгжүүлж, хөрвөлтөө гүнзгийрүүлэхэд тусалж чадна.

Энэ ангид сурсан сургаал, зарчим, мэдээллээ ашиглан дараах долоон асуултын гуравт хариул. (Танай багш тодорхой хэдэн асуултыг оноож өгч болно.) Ямар хариулт өгөхөө тунгаан бодохдоо “Хариулт” хэсэг дээрх зөвлөгөөг харна уу. Багшийнхаа товлосон шалгах өдөр хариултуудаа авчран, юу сурч мэдэн, хэрэгжүүлснээ хуваалцах бэлтгэлтэй ир.

Асуултууд

1. Та Тэнгэр дэх Эцэгээ хэрхэн илүү сайн таньж мэдсэн бэ?
2. Есүс Христийг болон Түүний Цагаатгалыг илүү бүрэн дүүрэн ойлгож, тэдгээрт найдахад тань юу тусалсан бэ?
3. Сайн мэдээний Сэргээлтийн талаарх таны гэрчлэл хэрхэн өссөн бэ?
4. Ариун сүмийн адислалд илүү бүрэн дүүрэн зохистой байхад танд юу тусалсан бэ?
5. Энэ ангид суралцсан ямар ямар үнэн таны амьдралыг адисалсан бэ?
6. Та _____ -ийн талаарх гэрчлэлээ хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ? (Багш энэ асуултын зарчим, сургаалыг оноож өгөх болно.)
7. Та _____ -ийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлсний ачаар амьдрал тань хэрхэн сайжирсан бэ? (Дараах сургаалын сэдвүүдээс НЭГийг сонго.)

- Бурхан Тэргүүтэн
- Авралын төлөвлөгөө
- Есүс Христийн Цагаатгал
- Сэргээлт
- Бошиглогчид ба илчлэлт
- Санваар ба санваарын түлхүүрүүд
- Ёслолууд ба гэрээнүүд
- Гэрлэлт ба гэр бүл
- Зарлигууд

Хариулт


Хариулт бүрдээ дараах зүйлсийг багтаах талаар бодож үз. Үүнд:

- Энэ ангид оролцсоноор таны хувьд илүү утга учиртай болсон *сургаалыг олж тогтоо*.
- Өөрийнхөө үгээр эсвэл судруудын хэсэг, амьд бошиглогчдын үгийг ашиглан аливаа *сургаалыг тайлбарла*.
- Ойрын үед амьдралдаа сургаалын хүчийг мэдэрсэн *туршлагаа хуваалу*.
- Таны туршлага Христийн сайн мэдээнд хөрвөлтөө гүнзгийрүүлэхэд тань хэрхэн тусалсан талаар *хуваалу*.

Анхаарах зүйл: Хэрэв та онцгой хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндийн асуудалтай бол багштайгаа ярилцан, энэ хөтөлбөрт хамрагдаж төгсөхөд тань тус болох зохицуулалтыг хийлгээрэй.

Тэмдэглэлийн дэвтэр

Та ойлгож сурсан зүйлсээ болон үүнийг хэрхэн хэрэгжүүлж байгаагаа мөн энэ нь таны Есүс Христэд итгэх итгэлийг хэрхэн өсгөн нэмэгдүүлсэн талаар байнга бичиж тэмдэглэдэг тэмдэглэлийн дэвтрээ үргэлжлүүлэн хөтөл. Энэ нь танд Бурханаас хүлээн авсан олон адислалаа эргэн харж мөн таних боломжийг олгоно. Энэ тэмдэглэл нь сүнслэг өдөөлт болон хүч чадлын эх сурвалж болж чадна. Курс төгсөх үеэр та тэмдэглэлийн дэвтэр тогтмол хөтөлсөн эсэхээ мөн энэ туршлага таны Есүс Христэд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлсэн талаар багшдаа тайлагнах болно.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г. Скотт (1928–2015):



Сүнснээс ойлгож авсан чухал зүйлсээ найдвартай газарт тэмдэглэж бай. Та үнэ цэнтэй сэтгэгдлээ бичиж байх тусам тийм сэтгэгдэл илүү олноороо ирэхийг харах болно. Мөн та олж авах мэдлэгээ амьдралынхаа турш ашиглах боломжтой байх болно” хэмээн заасан “To Acquire Knowledge and the Strength to Use It Wisely,” *Ensign*, 2002 оны 6-р сар, 32).

Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри Б. Айринг мөн сүнслэг мэдрэмжээ тэмдэглэхийн ач холбогдлын талаар ингэж хэлжээ.



“Би Сүмийн ажлаас гэртээ оройтож ирэв.

... Би хаалган дээрээ ирээд, ‘эдгээр туршлагыг зөвхөн чамд өгөөгүй юм. Тэдгээрийг бичээд ав’ гэх дуу хоолойг оюун санаандаа сонссон юм.

... Ингэснээр би оюун санаанд минь сонсогдсон тэр захиасыг ойлгов. Би хүүхдүүддээ уншихад нь зориулж бичих ёстой байлаа, тэгснээр ирээдүйд Бурханы гар гэр бүлийг маань хэрхэн адисалж байгааг харах болно. ...

Би өдөр бүр цөөн хэдэн мөрийг олон жилийн турш бичсэн билээ. ... Мөн би бичихээсээ өмнө ‘Би өнөөдөр Бурханы гар бидэнд, хүүхдүүдэд маань эсвэл гэр бүлийнхэнд маань хүрснийг харсан уу?’ гэсэн асуултыг эргэцүүлэн боддог. Намайг ингэж хөтөлж байхад зарим зүйл тохиолдож эхэлсэн. ...

Хүндэтгэлээс илүү зүйл зүрхэнд маань өсөж эхэлсэн юм. Гэрчлэл өссөн. Би Тэнгэрлэг Эцэг залбирлуудыг маань сонсож мөн хариулдагт илүү итгэлтэй болсон. Би Аврагч Есүс Христийн Цагаатгалаар ирдэг зөөлрүүлэлт болон цэвэршүүлэлтэд илүү хүндэтгэлтэй хандах болсон. Мөн би Ариун Сүнс бидэнд бүх зүйлийг, бүр тохиолдож байхад нь анзаараагүй юм уу анхаарал хандуулаагүй зүйлсийг хүртэл сануулдагт илүү итгэлтэй болсон (Хэнри Б. Айринг, “O Remember, Remember,” *Ensign* эсвэл *Liahona*, 2007 оны 11-р сар, 66–67).

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол 1 Нифай 1:1–3; 6:3–6; Алма 37:8–9;
3 Нифай 23:6–13; Мосе 6:5, 45-46-г үзнэ үү.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан зохицуулалт хийх нь

Суралцахуйг өндөрт гаргах туршлагын зохицуулалт хийхийн зорилго бол тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндтэй холбоотой асуудал бүхий суралцагчдыг үнэлгээний шалгалтад бусад суралцагчтай ижил түвшинд оролцуулахад оршино. Багш нар суралцагчдынхаа тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндтэй



холбоотой асуудлуудад зохих зохицуулалтыг хийх ёстой. Дараах зүйлс нь суралцагчдадаа зориулан зохицуулалт хийхэд удирдамж болно. Үүнд:

- Тусгай хэрэгцээ эсвэл хөгжлийн бэрхшээлтэй байж болох суралцагчдыг олж тодорхойл. Суралцагч бүрийн онцгой хэрэгцээг олж мэдэхийн тулд ганцаарчлан ярилц. Анхааралтай сонсож, өөдрөг ханд.
- Эцэг эх, Сүмийн удирдагчидтай хамтран суралцагчийн тусгай хэрэгцээнд тохируулан, зохицуулалт хийх төлөвлөгөө гарга. Суралцахуйг өндөрт гаргах туршлагыг суралцагчдад гэрт нь хийлгэхээр өгч болох боловч эцэг эхэд нь хүндрэлтэй байж болзошгүй тул болгоомжтой хандах хэрэгтэй. Суралцагчид, эцэг эхчүүдийн хувьд хамгийн үр дүнтэй байж болох шийдлийг тодорхойлохдоо хамгийн сайнаараа хичээнэ үү.
- Зохицуулалт хий. Хувь хүмүүст үзүүлсэн тусламжийн талаарх мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах ёстой. Боломжтой бүх зохицуулалтыг жагсаан бичих боломжгүй ч тодорхой хэдэн жишээг доор үзүүлэв.
 - *Танилцуулга:* Суралцагчдад Суралцахуйг өндөрт гаргах туршлагын аудио бичлэгийг өгөх, удирдамж ба үнэлгээг амаар уншиж танилцуулах, үнэлгээний том үсгээр хэвлэсэн хувилбарыг өгөх
 - *Хариулт:* Суралцагчийг Суралцахуйг өндөрт гаргах туршлагын хариултуудыг амаар өгөх, бичээчээр бичүүлэх, дуу хураах төхөөрөмжөөр бичиж өгөх зэрэг боломж олгоно.
- Суралцагчийн сурлагын түвшинг бууруулах эсвэл өөрчлөх зохицуулалт хийхээс зайлсхий.
- Суралцагч бүрд Христийнхтэй адил хайрыг үзүүлж, тэдний хэрэгцээнд нийцүүлэн зохицуулалт хийхдээ Сүнсний өдөөлтийг дага.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэх талаар ерөнхий мэдээлэл олж авахын тулд [lds.org/topics/disability](https://www.lds.org/topics/disability) вэбсайт руу орно уу.



ШАШНЫ ИНСТИТУТ
БА СЕМИНАР

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ